



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/ЗЧД

Эрдэнэт

### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “е”, 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3, Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.”Эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай давах чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулахыг Татварын хэлтэс /н.Өлзийсайхан/-т даалгасугай.


2.Тус ажлыг зохион байгуулахад шаардагдах 7.580.000 / Долоон сая таван зуун наян мянган / төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын  
19-ны өдрийн 1/340 дугаар захирамжийн хавсралт



ТАТВАРЫН ТӨЛӨГЧДИЙГ ТАТВАРТ ХАМРУУЛАХ, ТАТВАР  
ХУРААН БАРАГДУУЛАХ, ТАЙЛАНГИЙН ИРЦ ХАНГУУЛАХ  
АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Тухайн сарын зардал / төгрөг/	Тайлант жилд / төгрөг/
1	Татвар төлөгчдийг татварт хамруулах, татварын бүртгэл мэдээллийн санг үнэн зөв байлгах, татвар хураан барагдуулж төсвийн орлогыг бүрдүүлэх, татварын тайлангийн ирцийг хангуулах зорилгоор байцаагч нарт шаардлагатай харилцаа холбооны зардал	Байцаагчийн тоо	25	20.000	500.000	4.000.000
2	Татвар төлөгч нараас татвар хураан барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд, тухайлба, мэдэгдэх хуудас, албан мэдэгдэл, шаардлага хүргүүлэх шуудан үйлчилгээний зардал	Тухай бүр		200.000	200.000	1.600.000
3	Багуудын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, татварыг урьдчилан хураан барагдуулахтай холбоотой тээвэр, шатахууны зардал	литр	150	1650	247.500	1.980.000
	Нийт дүн					7.580.000